



НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН
ГАЗРЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



2026 VII

НАЛАЙХ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2022-2026 ОН	3
 ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	4-5
 НИЙГМИЙН ДААТГАЛ	5-7
 ЭРҮҮЛ МЭНД	7-8
 СОЁЛ УРЛАГ	9
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	9
 ГЭМТ ХЭРЭГ	10-11
 ТӨСӨВ	11
 ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ	12
 АЖ ҮЙЛДВЭР	13
 МАЛ АЖ АХУЙ	13-14
 ХАРИЛЦАА ХОЛБОО	14
 АЮУЛГҮЙ БАЙДАЛ	14- 15
 ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТ	16



ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

ХҮСНЭГТ 1. ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 7 сард

Үзүүлэлт	2022	2023	2024	2025	2026*
Суурин хүн ам, жилийн эцэст тоо	39 579	40 238	40 674	40 824	-
Шинээр төрсөн хүүхэд тоо	444	486	419	378	385
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн тоо	4394	253	189	196	232
Бүртгэсэн гэмт хэрэг тоо	2224	310	259	185	313
Орон нутгийн төсвийн орлого сая төгрөг	8 752.9	10 380.6	14 140.2	19 214.3	20 932.6
Орон нутгийн төсвийн зарлага сая төгрөг	9 049.3	10 019.8	14 044.3	19 099.8	22 568.2

Эх үүсвэр: Налайх дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэс



ИРГЭНИЙ БҮРТГЭЛ


2026 оны эхний 7 сард төрсөн 385 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн авч, нас барсан 169 хүнийг бүртгэлээс хасаж, 58 хосын гэрлэлт, 30 хосын гэр бүл цуцлалтыг тус тус бүртгэсэн байна.

Шинээр мэндэлсэн хүүхдийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 (1.8%), нас баралт 13 (8.3%)-иар тус тус өссөн байна. Нийт мэндэлсэн хүүхдийн 49.1 хувь нь хүү, 50.9 хувь нь охин байна. Нийт нас баралтын 69.2 хувь нь эрэгтэй, 30.8 хувь нь эмэгтэй хүн эзлэж байна.

ХҮСНЭГТ 2. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТЫН БҮРТГЭЛ, жил бүрийн эхний 7 сард

Үзүүлэлт	2022	2023	2024	2025	2026*
Төрсөн хүүхэд, бүгд	444	486	419	378	385
Үүнээс:					
Эрэгтэй	220	243	224	201	189
Эмэгтэй	224	243	195	177	196
Нас баралт, бүгд	150	158	171	156	169
Үүнээс:					
Эрэгтэй	100	92	109	99	117
Эмэгтэй	50	66	62	57	52

ЗУРАГ 1. ХҮН АМЫН ЕРДИЙН ЦЭВЭР ӨСӨЛТ



ХҮСНЭГТ 3. ГЭРЛЭЛТЭЭ БҮРТГҮҮЛСЭН ХОС, насны бүлгээр, жил бүрийн эхний 7 сард

Үзүүлэлт	2024		2025		2026*	
	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй
Нийт	100	100	65	65	58	58
18-19	1	3	-	-	-	1
20-24	15	28	13	16	6	7
25-29	35	28	15	18	19	23
30-34	21	16	10	8	11	10
35-39	3	3	15	11	7	5
40-44	7	5	6	8	8	6
45-49	10	8	2	1	3	2
50 +	8	9	4	3	4	4

2026 оны эхний 7 сард гэрлэлтээ баталгаажуулсан 58 хос байгааг өмнөх оны мөн үетэй 7 (10.8%)-иар буурсан байна. Хосуудыг насны бүлгээр нь авч үзвэл 0.9% нь 18-19 насны, 11.2% нь 20-24 насны, 36.2% нь 25-29 насны, 18.1% нь 30-34 насны, 10.3% нь 35-39 насны, 12.1% нь 40-44 насны, 4.3% нь 45-49 насны, 6.9% нь 50 дээш насныхан байна.

ХҮСНЭГТ 4. ГЭР БҮЛ ЦУЦЛАЛТ, жил бүрийн эхний 7 сар

Үзүүлэлт	2022	2023	2024	2025	2026*
Гэр бүл цуцлалт, бүгд	45	38	40	35	30
1 хүртэл	1	3	5	1	1
1-3	18	3	4	-	6
Гэр бүл байсан	4-6	8	4	6	7
хугацаагаар (жилээр)	7-9	-	7	9	6
10-14	4	8	10	7	5
15-19	4	6	3	9	8
20 ба түүнээс дээш	10	7	3	5	3

2026 оны эхний 7 сард нийт 30 хос гэр бүлээ цуцлуулсан байна. Гэр бүл байсан хугацаагаар нь ангилбал, 3.3% нь 1 хүртэлх, 20.0% нь 1-3 жил, 13.3% нь 4-6 жил, 10.0% нь 7-9 жил, 16.7% нь 10-14 жил, 26.7% нь 15-19 жил, 10.0% нь 20 түүнээс дээш жил ханилсан хосууд байна.

Дүүргийн хэмжээнд гэр бүл цуцлалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 (14.3%)-иар буурсан байна.

Дүүрэгт 2026 оны эхний 7 сард 7 хүүхэд үрчлэгдсэн байна.

ХҮСНЭГТ 5. ҮРЧЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ, насны бүлгээр, жил бүрийн эхний 7 сард

Үзүүлэлт	2022	2023	2024	2025	2026*
Үрчлэгдсэн хүүхэд, бүгд	5	15	7	7	3
0-3 хүртэл	-	11	3	2	1
3-6	-	-	-	4	-
7-9	2	2	1	-	1
10 ба түүнээс дээш	3	2	3	1	1

Эх үүсвэр: Налайх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс



НИЙГМИЙН ДААТГАЛ


2026 оны эхний 7 сард нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 16628.7 сая төгрөгт хүрч, нийгмийн даатгалын санд төвлөрчээ.

Нийгмийн даатгалын сангаас 2026 оны эхний 7 сард 42081 даатгуулагч иргэнд 45646.0 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон байна.

ХҮСНЭГТ 6. НИЙГМИЙНДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, жил бүрийн эхний 7 сард

Үзүүлэлт	2025		2026*	
	Даатгуу- лагчдын тоо	Олгосон дүн (сая.төг)	Даатгуу- лагчдын тоо	Олгосон дүн (сая.төг)
Нийт орлого	-	14 435.8	-	16 628.7
Тэтгэврийн даатгалын сан	-	12 091.6	-	13 917.4
Тэтгэмжийн даатгалын сан	-	1 288.6	-	1 484.4
ҮОМШӨ-ний даатгалын сан	-	629.5	-	730.6
Ажилгүйдлийн даатгалын сан	-	426.1	-	496.3
Нийт зардал	43 183	40 620.8	42 081	45 646.0
Тэтгэврийн даатгалын сан	40 177	34 663.5	35 269	39 111.9
Өндөр насны тэтгэвэр	29 287	25 038.4	26 131	28 633.7
Тахир дутуугийн тэтгэвэр	5 405	3 388.5	4 263	3 551.9
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	2 189	1 308.0	1 760	1 473.3
Цэргийн тэтгэвэр	3 296	4 928.6	3 115	5 453.0
ҮОМШӨ-ний даатгалын сан	2 031	2 459.5	2 253	2 508.7
Тахир дутуугийн тэтгэвэр	1 891	2 344.7	2 115	2 410.6
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	90	87.9	98	90.2
Сувилалын зардал	46	4.1	33	1.7
ҮОМШӨ ХЧТА ¹	4	22.8	7	6.2
Тэтгэмжийн даатгалын сан	511	1 841.2	2 563	1 889.5
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	186	148.6	1 030	101.8
Жирэмсний амралт	250	1 480.6	1 118	1 443.7
Оршуулга	75	212.0	415	344.0
Ажилгүйдлийн даатгалын сан	464	1 656.6	1 996	2 135.9
Ажилгүйдлийн тэтгэмж	464	1 656.6	1 996	2 135.9

ЗУРАГ 2. ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА



Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо эхний 7 сард 35269 иргэнд олгосон тэтгэврийн 39111.9 сая төгрөгт хүрчээ. Олгосон нийт тэтгэврийн 73.2 хувийг өндөр насны, 9.1 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 3.8 хувийг тэжээгчээ алдсан, 13.9 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.

Эх үүсвэр: Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газар

¹ Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн чадвараа түр алдсан



ЭРҮҮЛ МЭНД

2026 оны эхний 7 сард амаржсан эхийн тоо өмнөх оны мөн харьцуулахад 37 хүнээр (9.9%), нас баралт 8 хүнээр (6.2%) тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 7. ТӨРӨЛТ, жил бүрийн эхний 7 сард

Үзүүлэлт	2022	2023	2024	2025	2026*
Амаржсан эхийн тоо, бүгд	467	503	397	372	409
Амьд төрсөн хүүхэд	474	508	401	372	409
Амьгүй төрсөн	3	1	5	1	2
Эхийн эндэгдэл	-	-	-	-	-
Нас баралт	137	150	150	129	137
Үүнээс: нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	4	8	3	7	7
Эмнэлгийн нөхцөлд гарсан нас баралт	12	11	27	38	41
Гэрийн нөхцөлд гарсан нас баралт	90	114	94	57	56
Улаанбаатар хотод бүртгэгдсэн нас баралт ²	35	25	29	34	40

2026 оны эхний 7 сард нийт нас баралтын 40.9 хувийг гэрийн орчин нөхцөлд гарсан нас баралт эзэлж байгаа бол 29.2 хувийг Улаанбаатар хотод хэвтэн эмчлүүлж байгаад нас барсан, 29.9 хувийг дүүргийн эмнэлэгт гарсан нас баралт эзэлж байна.

ХҮСНЭГТ 8. ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний 7 сард

Үзүүлэлт	2022	2023	2024	2025	2026*
Нийт халдварт өвчин	4394	253	189	196	232
Хурц халдварт өвчин:	4256	118	87	126	152
Хепатит В, С вирус	-	-	2	1	1
Менингит	-	-	-	1	-
Салхин цэцэг	9	28	60	19	25
Паротит	-	1	3	-	2
Дизентери	3	7	4	3	12
Ёлом	-	-	-	1	1
Бруцеллез	-	1	-	13	-
Гар, хөл, амны өвчин	2	19	14	2	46
Эритема B08.3	-	-	-	7	1
Хумхаа	-	1	-	-	-
Улаан эсэргэнэ	-	7	3	1	5
Сальмонеллөз	-	-	1	1	7
Улаан бурхан	1	-	-	66	30
B34.1	-	-	-	4	8
Бусад халдварт өвчин	-	-	-	5	10
Ковид	4241	54	-	-	-
Хачигт риккеттиоз	-	-	-	-	4
Арьс өнгөний өвчин	122	110	88	57	64
Тэмбүү	46	52	46	31	21
Заг хүйтэн	46	29	19	21	30
Бэлгийн замын мөөгөнцөр	5	16	15	-	-
Трихомониаз	25	13	8	5	13
Сүрьеэ	16	25	14	13	16

² Дүүргийн харьяат иргэдээс Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлж байгаад гарсан нас баралт

Дүүргийн хэмжээнд нийт халдварт өвчинг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36 хүнээр (18.4%), хурц халдварт өвчин 26 (20.6%), арьс өнгөний өвчлөл 7 (12.3%), сүрьеэ 3 (23.0%) тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 9. ЭМНЭЛГИЙН ҮЗЛЭГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 7 сард

Үзүүлэлт	2022	2023	2024	2025	2026*
Урьдчилан сэргийлэх тарилга	3 524	3 738	3 131	3 673	3 767
Амбулаторын үзлэг	129 292	127 483	135 771	138 580	130 060
Ор хоног	33 072	34 019	33 817	29 204	26 703
Эмчийн тоо	84	93	94	96	82
Сувилагчийн тоо	100	108	111	118	101
Орны тоо	325	227	227	245	245

ЗУРАГ 3. ЭМНЭЛГИЙН ҮЗЛЭГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Эх үүсвэр: Налайх дүүргийн эрүүл мэндийн төв



СОЁЛ УРЛАГ

Дүүргийн соёл, урлагийн байгууллага 2026 оны 7 сард үйлчилгээ явуулаагүй түр зогссон байна.

ХҮСНЭГТ 10. СОЁЛ, УРЛАГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 7 сард

Хүснэгт 10. СЭЗ, уламжлалт, дээр дурдсан, 7 сард									
Ажил үйлчилгээ	Нийт	Үүнээс						Номын сан (уншигчид)	ОНСТ үзэгчид
		Урлагийн тоглолт	Олон нийтийн ажил	Хурал цуглаан	Кино үзвэр	Уралдаан тэмцээн	Дугуйлан сургалт		
Бүгд									
Үйлчлүүлэгчийн тоо									
Нийт									
Том хүн									
Хүүхэд									

Эх үүсвэр : Налайх дүүргийн Соёлын ордон



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

2026 оны эхний 7 сард хот тохижилтын ажил үйлчилгээний нийт орлого 467.4 сая төгрөг болж, орлогын 43.9 хувийг орон сууц, 41.7 хувийг гэр хороолол, 14.4 хувийг аж ахуйн нэгжээс хуримтлуулсан орлого эзэлж, нийтдээ 78.7 мянган тонн хогийг зөөж, тээвэрлэсэн байна.

ХҮСНЭГТ 11. ХОТ ТОХИЖИЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 7 сард

Үзүүлэлт	2022	2023	2024	2025	2026*	Үүнээс:		
						Орон сууцны	Гэр хороолол	ААНБ
Нийт орлого сая / төг	173.7	178.2	428.3	398.7	467.4	205.0	195.0	67.4
Хог тээвэрлэлт мян / тн	31.6	30.3	88.9	59.8	78.7	27.6	30.4	20.7

Эх үүсвэр: Налайх дүүргийн Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар

2026 оны эхний 7 сард дүүргийн хэмжээнд 325.9 мянган м³ ус борлуулснаас, 171.2 мянган м³ (52.5%) усыг хүн амд, 154.7 мян.м³ (47.5%) усыг аж ахуйн нэгж байгууллагад түгээсэн байна.

ХҮСНЭГТ 12. ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ, жил бүрийн эхний 7 сард

Үзүүлэлт	2022	2023	2024	2025	2026*
Шахсан ус мянган м³	613.5	383.0	353.9	617.0	827.0
Борлуулсан ус мянган м³	378.6	262.5	251.0	343.7	325.9
Үүнээс: Хүн амд мянган м³	268.2	161.5	167.3	190.1	171.2
Аж ахуйн нэгж байгууллагад мянган м³	110.4	101.0	83.7	153.6	154.7
Татан зайлуулсан бохир мянган м³	316.7	220.3	207.7	245.9	261.0
Ус борлуулалтын орлого сая төгрөг	645.2	454.7	442.5	591.7	715.8
Сувагжуулалтын орлого сая төгрөг	334.6	158.9	270.7	453.3	405.4
Халаалтын орлого сая төгрөг	177.7	214.5	156.9	169.2	168.0


Эх үүсвэр: Налайх дүүргийн Чандмань Налайх ОНӨААТҮГазар



ГЭМТ ХЭРЭГ

Дүүрэгт 2026 оны эхний 7 сард 313 гэмт хэрэг бүртгэгдснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 128 (69.2%)-иар өссөн байна.


ЗУРАГ 4. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧИД, насны байдлаар



ХҮСНЭГТ 13. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний 7 сард

Үзүүлэлт		2022	2023	2024	2025	2026*
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд		224	310	259	185	313
Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг		4	9	2	2	20
Үүнээс	Санаатай	3	2	-	-	4
	Учрал	-	1	-	-	-
Хүчин		-	4	4	7	13
Бусдын бие махбодид гэмтэл учруулсан		99	85	119	74	87
Өмчлөх эрхийн гэмт хэрэг		45	112	84	80	46
Үүнээс	Хулгай	1	-	1	32	39
	Залилах	39	105	70	31	83
	Хөрөнгө завших	-	5	3	2	5
	Алдаатай гүйлгээ, гээгдсэн эд хөрөнгө завших	-	-	5	5	4
	Эд хөрөнгө устгах гэмтээх	-	-	4	4	8
	Авто тээвэр хэрэгсэл зөвшөөрөлгүй авч явах	-	-	1	2	1
	Дээрэм	5	2	-	4	3
Бусад		73	97	51	22	-
Гэмт хэрэгт холбогдогчид, бүгд		140	228	171	130	122
Ажилгүй		96	143	56	88	64
Албан хаагч		5	6	713	8	3
Оюутан, сурагч		12	16	4	4	5
Малчин		4	1	5	-	1
Төрийн бус байгууллагын ажилтан		2	8	88	2	1
ХХЭ болон хувийн хэвшилд ажиллагч		21	52	-	25	45
Тэнэмэл		-	1	-	2	3
Хугацаат цэрэг		-	-	-	1	-
Эрүүлжүүлэгдсэн хүн		1078	604	357	275	93
Үүнээс: Эмэгтэй		132	54	32	38	6

ЗУРАГ 5. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороодоор



Эх үүсвэр: Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс



ТӨСӨВ

2026 оны эхний 7 сард дүүргийн төсөвт 16540.0 сая төгрөгийн татварын орлого төвлөрсөн байна.

ЗУРАГ 6. ОРОН НУТГИЙН ТАТВАРЫН ОРЛОГО, төрлөөр



Эх үүсвэр: Налайх дүүргийн Татварын хэлтэс



ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ

Түүхий эдийн үнэ өмнөх оны мөн үеэс тэмээний шир 15000 төгрөг (25.0%), адууны сүүл 3000 төгрөг (30.0%), адууны дэл 500 төгрөг (33.3%), үхрийн шир 3500 төгрөг(53.8%) тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 14. ЗАРИМ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ, жил бүрийн эхний 7 сард

Түүхий эдийн нэр	2022	2023	2024	2025	2026*
	төгрөг				
Тэмээний шир ширхэг	-	-	-	10 000	25 000
Адууны шир ширхэг	8 000	10 000	10 000	-	-
Адууны дэл кг	7 000	5 000	3 000	1 500	2 000
Адууны сүүл кг	10 000	10 000	12 000	10 000	13 000
Үхрийн шир (дундаж үнэ) 1.8-2.3 метр хэмжээтэй ширхэг	7 500	10 000	15 000	6 500	10 000
Хонины ноостой арьс ширхэг	-	-	-	-	-
Ямааны ноолууртай арьс ширхэг	-	500	-	-	-
Ноолуур кг	-	-	110 000	-	-
Гахайн мах	-	-	-	-	9 000

ХҮСНЭГТ 15. ШАТАХУУН ҮНЭ, литр, төгрөг, жил бүрийн 7 сард

ШТС	2025. VII. 28					2026. VII. 27				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	-	-	2590	2940	-	-	-	2840	4190	-
Петровис	3510	2370	2590	2940	-	4110	-	2840	4190	-
Магнай трейд	3510	-	2590	2940	-	-	-	-	-	-
Сод монгол	3510	2315	2590	2940	-	4110	-	2840	4190	-
Шунхлай	3510	2350	2590	2940	-	4100	-	2840	4170	-
Юнигаз	-	-	-	-	1950	-	-	-	-	2150
Дундаж үнэ	3510	2345	2590	2490	1950	4106	-	2840	4185	2150

Эх үүсвэр: Нийслэлийн статистикийн газрын 7 хоногийн үнийн судалгааны дүн

ЗУРАГ 7. ШАТАХУУНЫ ДУНДАЖ ҮНЭ, литр төгрөг, 7 сард



АЖ ҮЙЛДВЭР

2026 оны эхний 7 сард үйлдвэрлэгдсэн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан хангамж 1.5 хувиар, цахилгаан эрчим хүч 5.4 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, жил бүрийн эхний 7 сард

Үзүүлэлт	Нийт үйлдвэрлэлт					
	Биет хэмжээгээр			Үнийн дүнгээр, сая/төг		
	2024	2025	2026*	2024	2025	2026*
Эрчим хүчний үйлдвэр						
Цахилгаан сая.квт.цаг	132.9	152.4	160.7	28 463.4	34 673.3	43606.3
Дулаан мянган гкал	57.7	53.0	53.8	3 234.8	5 650.4	4 832.7
Олборлох үйлдвэр						
Шохой тонн	9.8	-	-	148.8	-	-
Элс мянган м³	22.9	14.1	7.4	346.1	231.9	152.5
Хайрга мянган м³	4.3	608.4	7.2	73.4	498.1	198.3
Дайрга мянган м³	0.3	-	12.8	4.2	-	131.4

Боловсруулах үйлдвэр						
Тоосго мян.ширхэг	2 888.2	1 992.7	4 279.0	626.8	917.8	1 510.5
Цемент мянган.тонн	10.9	12.0	14.1	2 475.7	3 166.3	3 996.2
Бетон зуурмаг мянган.тонн	13.7	11.9	10.9	3 425.5	2 503.2	3132.5
Аюултай хог хаягдал булах тонн	496.1	646.2	790.5	664.8	900.6	1 058.7
Аюулгүй хог хаягдал зайлуулах тонн	88.9	58.9	78.7	1 200.0	1 535.2	1 028.7
Оёдол /сурагчийн дүрэмт хувцас/ мянган ширхэг	-	8.4	0.9	-	370.2	53.7
Берзінтэн цүнх ширхэг	-	2.6	0.7	-	127.3	44.9
Резинэн эдлэл сая.төг	2 647.0	3 180.4	9 039.7	2 647.0	3 180.4	9 039.7
Хүндрүүлэгч ширхэг	5 600.0	5 467.6	-	5 600.0	5 467.6	-
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл						
Талх тонн	3.5	12.5	10.6	13.6	52.7	42.4
Нарийн боов, жигнэмэг тонн	4.8	12.1	18.1	18.2	47.2	92.4
Цэвэр ус мян. литр	6 597.9	4 438.6	3639.9	2 643.3	2 067.7	2 457.1

*Урьдчилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: Дүүргийн аж үйлдвэрийн мэдээ



МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО

Телефон цэгийн тоо өмнөх оны мөн үеэс 10 (1.3%) өссөн байна. Нийт суурин телефон цэгийн 413 (53.9%) нь айл өрхийн эзэмшилд байгаа бол 251 (32.9%) нь төсвийн байгууллагад, 101 (13.2%) нь бизнесийн байгууллагуудад ашиглагдаж байна.

ХҮСНЭГТ 18. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 7 сард

Үзүүлэлт	2022	2023	2024	2025	2026*
Нийт орлого сая төгрөг	214.6	406.0	318.4	327.9	357.0
Үүнээс: хүн амд үзүүлсэн үйлчилгээний сая төгрөг	105.1	198.9	156.0	160.7	174.9
Телефон цэг тоо	967	905	866	755	765
Үүнээс: айл өрх тоо	568	503	466	396	413
Интернет үйлчилгээний цэг тоо	2	2	2	2	2
Интернет үйлчилгээний суудал тоо	17	2	2	2	2
Интернет үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчид тоо	450	350	400	180	350
Интернетиин байнгын хэрэглэгчид тоо	517	659	500	590	462



АЮУЛГҮЙ БАЙДАЛ

2026 оны эхний 7 сард гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг 120 объектод хийснээс, 560 зөрчил илрүүлэн, 520 зөрчлийг арилгуулан, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх

албан шаардлага 65, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 40, танилцуулга 1, гал түймэр унтраасан нотломж 66, гал түймэр гаргасан тухай акт 18 хүргүүлсэн байна.

Мөн объектын гал түймрийн 66 дуудлагаар ажиллаж 1658.0 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

ХҮСНЭГТ 19. ГАЛ ТҮЙМРИЙН ДУУДЛАГА, жил бүрийн эхний 7 сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022	2023	2024	2025	2026*
Бүгд	тоо	39	43	55	87	66
Өмчийн хэлбэрээр						
Төрийн өмч	тоо	3	1	-	-	-
Хувийн өмч	тоо	32	37	32	72	62
Аж ахуйн нэгж	тоо	4	5	23	15	4
Гал түймэрт өртөж шатсан						
Нас барсан	Том хүн	-	-	-	-	2
	хүүхэд	-	-	-	-	-
Өвөл зуны сууц	тоо	7	15	26	45	18
Гэр	тоо	10	17	10	18	24
Хог, хогийн суваг	тоо	8	11	8	13	12
Машин техник	тоо	5	-	6	5	7
Барилга байгууламж	тоо	6	-	3	4	1
Малын хашаа саравч	тоо	3	-	2	2	4
Шалтгаан						
Цахилгааны	тоо	19	21	36	56	53
Ил задгай асгасан үнс, нурмаас	тоо	7	6	-	18	-
Лаа, тамхи, шүдэнз	тоо	1	4	-	-	-
Пийшин зуухны цоолт	тоо	6	12	10	9	5
Машин техник гэмтэл, буруу ашигласан	тоо	2	-	-	1	3
Архидан согтуурснаас	тоо	-	-	1	-	-
Бусад	тоо	4	-	-	1	-
Шалтгаан тогтоогдоогүй	тоо	-	-	3	2	5
Аварсан эд хөрөнгө						
Өвөл зуны сууц	тоо	3	6	-	30	6
Гэр	тоо	-	-	6	-	6
Барилга байгууламж	тоо	6	3	4	32	14
Машин техник	тоо	5	3	4	-	-
Галын онц аюултай объект	тоо	3	-	1	-	-
Малын хашаа саравч	тоо	-	-	1	-	-
Аварсан эд хөрөнгө	Сая.төг	1 595.0	1 682.0	9 444.0	2 150.5	1 658.0

Эх үүсвэр: Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс

2026 оны эхний эхний 7 сард дүүргийн Засаг даргын 16 удаагийн захирамжаар нийт 762 иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой захирамж гарсанаас 736 иргэн, 26 аж ахуйн нэгж байгууллагын асуудлыг шийдвэрлэсэн. Албаны даргын 41 удаагийн тушаалаар нийт 1030 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын захирамж гарсанаас 1005 иргэн, 25 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн байна.

ХҮСНЭГТ 20. ГАЗАРТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭЛТ, жил бүрийн эхний 7 сард

Зориулалт	Газрын хэмжээг өөрчлөх	Газар эзэмших эрхийг хүчингүй болгох	Газар эзэмших эрх олгох, баталгаажуулах	Газар эзэмших эрхийг шилжүүлэх	Газар өмчлөх	Хамтран өмчлөгч хасуулах	Газрын байршил, талбайг өөрчлөх	Газар эзэмших эрх сэргээх хугацаа сунгах	Газар эзэмших эрхээ цуцлуулах хүсэлт гаргасан
Иргэн, ААНБ-ын тоо	43	4	642	933	-	-	47	97	2

Эх үүсвэр: Налайх дүүргийн Газар зохион байгуулалтын алба



ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭЛТ

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэх, хариу өгөх, хяналт тавих, тайлагнах ажлыг “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ”-аар явуулж байгаагийн зэрэгцээ “Налайх сонсож байна” 7023-2727, 1800-1200 тусгай дугаарын утас, Засгийн газрын 11-11 утас, www.ub1200.mn цахим хуудас, дижитал сити, Check my service аппликейшн зэргээр иргэдийн гомдол, хүсэлт, саналыг хүлээн авч байна.

2026 оны эхний 7 сард дүүргийн Засаг Даргын Тамгын газарт нийт 1024 санал, хүсэлт, өргөдөл хүлээн авсан байна. Эдгээрээс 1002 санал, хүсэлт, өргөдөлд хариу өгч, 21-д хариу өгөх хугацаа болоогүй болон судлагдаж байна. Санал хүсэлтийн шийдвэрлэлт 97.0 хувьтай байна. Ирсэн өргөдөл, гомдол саналын 781 (76.3%) нь бичгээр, 243 (23.7%) нь утсаар болон цахим системээр ирсэн байна.

Эх үүсвэр: Налайх дүүргийн ЗДТГ-ын нэг цонхны үйлчилгээ

Танилцуулгыг татаж авах линк : <http://www.ubstat.mn/Report>
Налайх дүүргийн Статистикийн хэлтэс facebook page хуудас
Утас: 7023-3672